



**МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 03 сарын 20 өдөр

Дугаар М/Н

Улаанбаатар хот

Ёс зүйн зөвлөл байгуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоол, "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.10.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын ёс зүйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ёс зүйн зөвлөлийн дарга	Орлогч дарга
Гишүүд	Хууль, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн Эдийн засаг Мастер
Нарийн бичгийн дарга	Маркетингийн ахлах мэргэжилтэн


2. Ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2018 оны А/03, А/31 тоот тушаалуудыг тус тус хүчингүйд тооцсугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Р.Дашгомбо/- д үүрэг болгосугай

ДАРГА



Д.ХАТАНБААТАР

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын
даргын 2019 оны 03 дугаар сарын 09 ны
өдрийн 04 дугаар тушаалын хавсралт



МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР ОНӨТҮГ-ЫН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын дэргэдэх ёс зүйн зөвлөл нь /Цаашид зөвлөл гэх/ төрийн үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэлтэй холбоотой гомдол, мэдээлэл байгууллагын удирдлагаас гаргасан саналыг хэлэлцэж зөрчил гаргагчид Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 4.2-т заасан хариуцлагыг хүлээлгэх хурлын тэмдэглэл гаргана.

1.2 Ёс зүйн зөвлөл нь Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөж ажиллана.

Хоёр. Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн

2.1 Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.2 Зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиллах журмыг газрын даргын тушаалаар батална.

2.3 Зөвлөл нь 5 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд Зөвлөлийн дарга нь байгууллагын орлогч дарга байна.

Гурав. Зөвлөл, зөвлөлийн дарга, гишүүний эрх үүрэг

3.1 Зөвлөл нь дараах эрх үүрэгтэй байна.

3.1.1 Төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчил гаргасан талаарх өргөдөл гомдол мэдээллийг хянаж, дүгнэлт гаргах

3.1.2 Албан хаагчдыг ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, ажил зохион байгуулах.

3.2 Зөвлөлийн дарга нь дараах эрх, үүрэгтэй байна.

3.2.1 Зөвлөлийн хурлын /цаашид хурал гэх/ бэлтгэл ажлыг хангуулах, товлон зарлах, хурлыг даргалах

3.2.2 Албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан талаарх өргөдөл гомдол, мэдээллийг хянуулахаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэнд даалгах.

3.3 Зөвлөлийн гишүүд нь дараах эрх, үүрэгтэй

3.3.1 Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан санал өгөх үүрэгтэй

3.3.2 Хурлын зохион байгуулалт, үйл ажиллагаа болон хувь хүний нууцтай холбоотой асуудлын нууцыг чандлан хадгалах үүрэгтэй..

3.3.3 Хурлын нарийн бичгийн дарга тэмдэглэл хөтөлж, хурлын зохион байгуулалтыг хийх үүрэгтэй.

3.3.4 Хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан зөвлөлийн гишүүний хувиар үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй

3.3.5 Хурлын тэмдэглэлд Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

3.3.6 Зөрчил гаргасан ажилтны уучлалт гуйлгах хэлбэрийг зөвлөлийн гишүүд тодорхойлно.

3.3.7 Зөвлөл нь гомдол мэдээлэлтэй холбоотой асуудлаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтний танилцуулгыг үндэслэж шийдвэрээ гаргана

3.3.8 Зөвлөл нь гомдол, мэдээллийг хэрхэн шийдвэрлэсэн талаар зөрчил гаргагч болон гомдол гаргагч нарт шийдвэрээ албан ёсоор танилцуулна.

Дөрөв. Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт

4.1 Зөвлөл хуралдах шаардлагыг үндэслэн зөвлөлийн дарга хурлын товыг хэдийд ч тогтож болно.

4.2 Зөвлөлийн гишүүдийн талаас илүү буюу 3-аас багагүй хүн оролцсон тохиолдолд хурал хүчин төгөлдөр болно.

4.3 Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан санал хураалтыг нээлттэй явуулж, ердийн олонхийн саналаар шийдвэрийг батална. Санал тэнцсэн тохиолдолд зөвлөлийн дарга шийдвэрийг гаргана.

4.4 Хуралд холбогдох этгээд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас биечлэн ирээгүй тохиолдолд түүний эзгүйд асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж гишүүдийн ердийн олонх үзвэл хурлыг хуралдуулна.

4.5 Зөвлөлийн гишүүнтэй холбогдсон ёс зүйн асуудлыг хэлэлцэж буй хуралд уг гишүүн санал өгөх эрхгүй.

4.6 Зөвлөл нь жилд нэг удаа Байгууллагын даргын дэргэдэх зөвлөлд ажлаа тайлагнана.

4.7 Зөвлөлийн шийдвэрийг байгууллагын даргад тухай бүр хүргүүлнэ.

4.8 Зөрчлийн шинж байдлыг харгалзан хариуцлага хүлээлгэх хурлын тэмдэглэл гаргана.

Тав. Бусад

5.1 Зөвлөлийн ажиллах журмыг зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Байгууллагын дарга нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

xxxxxXXXXXxxxxx